

ЕБС-ийн сурах бичгийн эх зохиох, хэвлэн нийтлэх зураглал

Ж.Дэнсмаа^{3}, Д.Пунцагсүрэн, Н.Хулан*
Боловсролын хүрээлэн, Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор

Хураангуй

Сүүлийн 5-6 жилийн хугацаанд ЕБС-ийн I-XII ангийн сурах бичгийг сургалтын цөм хөтөлбөрт нийцүүлэн шинээр зохиож, хэвлэж, хэрэглэж байна. Энэ хугацаанд сурах бичиг хугацаандаа хэрэглэгчдийн гар дээр очихгүй байх, сурах бичиггүй хичээллэх, өмнөх хөтөлбөрийн сурах бичгийг шинээр хэрэгжүүлж буй цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэглэх зэрэг сөрөг үр дагаврууд гарсан. Мөн дунд, ахлах ангийн сурагчдын сурах бичгийн хангалт тааруу, хүртээмжгүй байгаа нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж байна. Энэ судалгааны ажилд бид дээрх хугацаанд сурах бичгийн эх зохиох, хянах, хэвлэх үйл ажиллагааг зохион байгуулахад баталж мөрдсөн тушаал, шийдвэр, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийсэн. Нийт 122 сурах бичгийн эхийг зохиоход давхардсан тоогоор 850 орчим зохиогч, редактор ажиллажээ. I-XII ангийн сурах бичгийг сургалтын цөм хөтөлбөрт нийцүүлэн шинэчлэн зохиох ажлыг 3 жилийн хугацаатайгаар төлөвлөсөн боловч бодит байдалд 5-6 жилд хийсэн. Энэ нь бага, дунд, ахлах ангийн сурах бичгүүдийг шат дараатай шинээр зохиох ажилд хүний нөөц чадавх, санхүү хөрөнгийн боломж зэргийг сайтар тооцож, бодитой төлөвлөлт хийгээгүйг харуулж хүрч байна. БСШУС-ын сайдын 2018 оны А/549 дүгээр тушаалаар ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлалыг баталсан. Уг аргачлалд сургалтын хөтөлбөр, сурах бичгийг судалгааны үндэстэй боловсруулах, сайжруулах, танилцуулах, хэрэгжүүлэх цикло үйл ажиллагааг 10 жилээр төлөвлөсөн. Үүний дагуу ЕБС-ийн сурах бичгийн талаар баримтлах бодлого, зохицуулалтын баримт бичгийг илүү боловсронгуй болгох хэрэгцээ байна. Цаашид дээрх хэмжээний сурах бичгийг шинэчлэх, сайжруулахад 1200-1300 орчим хүн, түвшин бүрийн сурах бичгийг шинэчлэхэд 6-8 жил, зарцуулах зардалд 6.5 тэрбум төгрөг шаардлагатай. Харин сурах бичгийн эхийг зохиоход 1.5-2 жил, хэлэлцүүлэхэд 1 жил, сайжруулахад 0.5-1 жилийн хугацаа байх хэрэгтэйг ХМЦ-ийг үндэслэн төлөвлөж байна. Энэхүү өгүүлэлд дээр дурдсан чиглэлээр хийж буй судалгааны ажлын зарим үр дүн, шийдлүүдийн талаар авч үзлээ.

Түлхүүр үг

Сурах бичиг, зохиогч, хүний нөөц, цаг хугацаа, төлөвлөлт, зардал

Удиртгал

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Зөв монгол хүүхэд”⁴ үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд түүнийг 3 дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Тэдгээрийн нэг нь БДБШ-ийн дэд хөтөлбөр юм. Уг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх “ерөнхий зураглал”⁵-д сургалтын цөм хөтөлбөрийн үзэл баримтлал, агуулга, сургалтын болон үнэлгээний арга зүйд нийцсэн сурах бичгийг шинээр зохиох, турших, хэвлэх ажлыг 2013-2018 оны хооронд зохион байгуулсан байна. Сурах бичгийн эхэд MNS 5418:2008 “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага”-ыг, зохиох, хэвлэх, түгээх үйл ажиллагаанд “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”⁶-ыг мөрдөн ажилладаг. Энэ хугацаанд I-XII ангийн бүх сурах бичгийг зохиох, хянах үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн баримт бичиг, тушаал, дүрэм, журам, ажлын төлөвлөгөө, тайлан зэрэгт баримт бичгийн шинжилгээ хийсэн.

Судалгааны арга зүй

Энэ хугацаанд шинэчилж зохиосон сурах бичиг, багшийн номын тоо, хэмжээ (хэвлэлийн хуудас), зохиогчийн тоог Хүснэгт 1-д үзүүлэв.

^{3*} ✉ densmaa@mier.mn

⁴Засгийн газрын 2013 оны 295 дугаар тогтоолын хавсралтаар баталсан.

⁵БСШУ-ны сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын хавсралтаар баталсан.

⁶БСШУ-ы сайдын 2009 оны 131 дүгээр тушаалын хавсралтаар баталсан.

Хүснэгт 1

Сурах бичиг, багшийн номын тоо, хэвлэлийн хуудас, зохиогчийн тоо

түвшин	тоо (сурах бичиг/ багшийн ном)	хэмжээ (сурах бичиг/ багшийн ном)	зохиогчийн тоо	
			сурах бичиг	багшийн ном
бага	32/38	328/370 х.х	95	107
дунд	55/48	651/566 х.х	350	179
ахлах	35/13	458/260 х.х	262	124

Нийт 122 нэрийн сурах бичгийн эх зохиох, 99 нэрийн багшийн ном боловсруулахад давхардсан тоогоор 719⁷ зохиогч, сурах бичгийн эхийг 280, багшийн номын эхийг 241 редакторууд хянаж ажилласан байна. Нийт зохиогчийн 49.0 хувийг нь их дээд сургуулийн багш, 18.0 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, мэргэжилтэн, 27.0 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш, 6.0 орчим хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл бүрдүүлсэн байна. Бага ангийн сурах бичгийн зохиогчдын 3 хүн тутмын нэг нь их, дээд сургуулийн багш байсан бол ахлах ангийн сурах бичгийн зохиогчдын 2 хүн тутмын нэг нь их, дээд сургуулийн багш байв.

Хүснэгт 2

Нэг сурах бичигт ажиллах гишүүн болон нүүрийн тоо

түвшин	гишүүний тоо (дундаж)	Нүүрний тоо (дундаж)
бага	5-6	100-110
дунд	6-7	130-140
ахлах	7-8	160-170

Нэг ангийн түвшинд ойролцоогоор 30-35 сурах бичиг, нэг судлагдахууны сурах бичгийг 3-4 ангиар нь шинэчлэх ажил хийжээ. Иймд тухайн судлагдахууны сурах бичигт ажиллаж буй зохиогч зөвхөн нэг биш, 2-3 сурах бичигт ажиллах, нэмээд багшийн ном боловсруулах ажилд оролцсон. Мөн дээрх хугацаанд тухайн түвшний судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийн боловсруулалтад ажилласан сурах бичгийн зохиогч ч багагүй хувийг эзэлж байна. Нийт зохиогчдын дунджаар 30.0 орчим хувь нь 2-3 сурах бичигт, 40.0 орчим хувь нь тийм тооны багшийн ном дээр ажилласан байна.

Харин зохиогчийн хоёр хүн тутмын нэг нь сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад давхар ажиллажээ.

Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянахаас эхлээд эх бэлтгэх, хэвлэх, түгээх зэрэг сургалтад хэрэглэхэд бэлэн болгох бүхий л үйл ажиллагааг ямар хугацаанд төлөвлөсөн хийгээд түүнд зарцуулсан хугацаанд шинжилгээ хийв. Ангийн түвшнээр нь дараалуулж, гурван жилийн хугацаанд I-XII ангийн бүх сурах бичгийг шинэчлэн сургалтад хэрэглэж эхлэхээр төлөвлөсөн⁸ боловч бодит байдалд ямар хугацаанд гүйцэтгэснийг дараах үр дүнгүүдээс харж болно.

Нэг хичээлийн жилд нэг түвшний сурах бичгийг зохиохоор төлөвлөсөн боловч дунд ангийн сурах бичгийг 3 жилд, ахлах ангийн сурах бичгийг 2 жилд хуваан боловсруулсан байна. I-XII ангийн сурах бичгийг 4 удаагийн үйл ажиллагааны хүрээнд шинэчилсэн. Өөрөөр хэлбэл 4 удаагийн сайдын тушаалаар томилогдсон зохиогчийн баг 122 нэрийн сурах бичиг, 99 нэрийн багшийн номыг хэрхэн хуваан зохиосныг Хүснэгт 3-д үзүүлэв.

Хүснэгтээс харахад нэг удаад дунджаар 30-31 тооны сурах бичиг, 33 нэрийн багшийн номыг шинэчлэх ажлыг хийсэн байна. Ийм тооны сурах бичиг, багшийн номыг зохиоход 200-250 зохиогч, 75-80 редактор, 4-6 хэвлэлийн газрын 15-20 эх бэлтгэгч, менежер зэрэг нийт 350 орчим хүмүүс 10-12 сарын хугацаанд ажилласан байна.

Хүснэгт 3

Сурах бичиг, багшийн номын тоо

түвшин	I ¹	II ²	III ³	IV ⁴
бага анги	сурах бичиг-32 багшийн ном-38			
дунд анги		сурах бичиг-29 багшийн ном-48		
			сурах бичиг-19	
				сурах бичиг-7
ахлах анги			сурах бичиг-22 багшийн ном-13	
				сурах бичиг-13

⁸БШУ-ы сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн ерөнхий зураглал”

⁷давхардсан тоо

Эндээс БДБШ-ийн ерөнхий зураглалд дунд ангийн 55 нэрийн сурах бичгийг нэг жил шинэчлэн зохиохоор төлөвлөсөн нь хүний нөөцийн хувьд бодитой төлөвлөлт болоогүйг нотолж байна. Өөрөөр хэлбэл нэг удаа ийм тооны

сурах бичгийг зохиох хүний нөөцгүй байна. Хүснэгт 4-д түвшин бүрийн сурах бичиг зохиох үйл ажиллагааг ямар хугацаанд төлөвлөсөн болон гүйцэтгэснийг харуулав.

Хүснэгт 4

Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, эх бэлтгэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	2013	2014	2015	2016	2017	2018
I	төлөвлөсөн(бага)					
	гүйцэтгэсэн (бага)					
II		төлөвлөсөн (дунд)				
		гүйцэтгэсэн (дунд)				
III					гүйцэтгэсэн (дунд)	
IV						гүйцэтгэсэн (дунд)
III			төлөвлөсөн (ахлах)			
IV					гүйцэтгэсэн (ахлах)	
						гүйцэтгэсэн (ахлах)

Эндээс бага ангийн сурах бичгийг төлөвлөснөөс 2 сараар илүү хугацаанд боловсруулсан бөгөөд дунд, ахлах ангийн сурах бичгийн эх зохиох ажлыг төлөвлөснөөс 5-12 сарын дараа эхэлсэн нь харагдаж байна. Үүнд сурах бичгийн жагсаалт гаргах, зохиогчийн багийг бүрдүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн зардал тооцоог баталгаажуулахад шаардагдах хугацааг төлөвлөөгүй нь нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл бэлтгэл ажилд зарцуулах хугацаа байхгүй. Шинээр зохиох сурах бичгийн жагсаалт батлагдсаны дараа зохиогчийн багийг сонгох, бүрдүүлэхэд 3-4 сар зарцуулдаг. Гэтэл энэ хугацааг эх зохиох хугацаатай хамтад нь авч үзсэнээс эх зохиох ажил цагтаа эхэлдэггүй, хугацаа багасах нэг шалтгаан болсон байна.

Мөн сурах бичгийн талаар баримтлах бодлого, зохицуулалтын баримт бичиг (БШУ-ы сайдын 2009 оны 131 дүгээр журам)-т баг бүрдүүлэх, эх зохиох, хянах зэрэг үйл ажиллагааны гинжин хэлхээ бүрд шаардагдах цаг хугацааны зохицуулалтыг тусгаагүй байдаг нь дутагдалтай байна. Сурах бичгийн эх зохиох, хянах, эх бэлтгэлд зарцуулах хугацаа дунджаар 8-10 сар байна. Үүний 6-7 сар нь эх зохиох, 2-3 сар нь хянах, эх бэлтгэхэд зарцуулагдана. Сурах бичиг зохиоход дээрх хугацаа хангалтгүй байгаа талаар зохиогчид санал ирүүлж байна. Эх зохиох хугацаа бага байх нь сурах бичгийн чанарт нөлөөлнө. Өөрөөр хэлбэл сурах бичгийн чанарт чухал нөлөө үзүүлэгч хүчин зүйл бол түүнийг зохиох хугацаа болон нарийн төлөвлөлт юм. Иймд зохиогчийн баг бүрдүүлэх, эх зохиох, хянах, эх бэлтгэх, хэвлэх бүхий л үйл ажиллагааны төлөвлөлтийг хүний нөөц болон санхүүгийн

боломжоо бодитой тооцсон, нарийвчилсан төлөвлөлт хийх шаардлагатай.

Сурах бичгийн чанарт мэргэжлийн редакторын оролцоо, үүрэг, хариуцлага чухал. Сурах бичигт сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн эсэх, тухайн насны хүүхдийн танин мэдэхүйн онцлогт тохирсон эсэх, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг дэмжсэн дасгал, даалгавартай эсэхийг хянах, зөвлөх үүрэг бүхий агуулгын редактор, сурах бичгийн бичвэрийг хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй эсэх, техникийн шаардлагыг хангасан эсэхийг хянах, засах үүрэг бүхий техникийн редактор ажилладаг. Редакторын нэг удаагийн уншилтад зарцуулах хугацааг 5-7 хоног байхаар төлөвлөсөн боловч бодит байдал дээр энэ нь хангалтгүй байсан. 140-150 хуудастай сурах бичгийг ийм хугацаанд хянах, зөвлөгөө өгөх боломж бага байна.

Япон улсын сурах бичгийн зохиогчид сурах бичгийг чанаргүй, муу байгаагийн шалтгааныг зохиогчийн заах аргын талаарх мэдлэг чадвар дутагдалтай, хэвлэлийн газрын үйл ажиллагаа доголдолтой, “сайн” редактор, шүүмжлэгч, хэлний зөвлөх байхгүй, хэрэглэгч (багш, сурагч)-ийн дуу хоолойг анхаарч сонсохгүй байхтай холбон тайлбарлажээ (Textbook policies in Asia, 2018, 16 дугаар тал). Бага ангийн сурах бичигт редакторуудаас гадна ерөнхий боловсролын сургуулийн багш нарын төлөөллөөс бүрдсэн мэргэжил арга зүйн зөвлөл (МАЗ), хэрэглэгч, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн баг ажиллаж, сайжруулах талаар санал бодлоо илэрхийлсэн. Гэтэл дунд болон ахлах ангийн сурах бичигт хугацаа болон санхүүгийн хязгаарлагдмал нөхцөлөөс үүдэн олон нийтийн төлөөллийг

оролцуулаагүй. Зөвхөн редактороор хязгаарлах биш хэрэглэгч (багш, сурагч, эцэг эх)-ийн санал бодлыг тусгах, олон удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг тусгаж сурах бичгийг сайжруулахын зэрэгцээ таниулах, нэгдсэн нэг ойлголттой бий болгох үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй байна.

Нийт 122 сурах бичиг, 99 багшийн номын эх зохиох, хянахад 4.1 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд хянах зардал нь эх зохиох зардлын 10.0 хувьтай тэнцдэг. Үүнийг ажилласан хугацаанд хувааж үзэхэд нэг зохиогч сард дунджаар 350 орчим мянган төгрөгийн үнэлгээтэй ажилласан байна. Харин ахлах ангийн сурах бичгийн зохиогчдын сарын ажлын хөлс энэ дунджаас бага буюу 260 орчим мянган төгрөг байна.

Санхүү, зардлын тодорхойгүй байдлаас үүдэн үйл ажиллагаа доголдох, хугацаанаас хоцрох үзэгдэл багагүй гарсан. Жишээ нь: 2015 оны 1 дүгээр сард зохиогчийн багийг баталгаажуулсан боловч шаардагдах санхүү, зардал байхгүйн улмаас зохиогчтой 6 дугаар сард ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Аливаа ажлыг гэрээ байгуулснаас хойш эхэлсэнд тооцох тул эх зохиох хугацаа хойшилж, улмаар сурагчдын гар дээр хугацаандаа сурах бичиг очихгүй байх тохиолдол гарч байна. Сурах бичиг, багшийн номын боловсруулалт, хяналт, үйл ажиллагаа, эх бэлтгэл, хэвлэлд зарцуулах санхүү зардлыг тооцоолж, тодорхой хугацааны өмнө баталгаажуулсан байх шаардлагатай юм.

Хүний нөөц, санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэн 2017, 2018 онуудад багшийн номыг боловсруулаагүй. Зөвхөн сонгон судлах хичээлийг заах багшид зөвлөмж болгон 14 нэрийн багшийн номыг хэвлэсэн. Мөн сонгон судлах хөтөлбөрөөр хичээллэж байгаа сурагчдад хэрэглэх сурах бичиг одоогоор байхгүй байна. Тэгэхээр ахлах ангийн сонголттой хөтөлбөрөөр хичээллэх сурагчдын сурах бичиг болон нэмэлт сургалтын материал, дасгал ажлын дэвтер, багшийн номын талаар баримтлах бодлогыг тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны үр дүн

Сурах бичгийг зохиох, хэвлэхэд ажиллах хүний нөөц, санхүү хөрөнгийн боломж, гүйцэтгэл, үр дүнг бодитой тооцоолсон урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтыг нарийвчлан авч үзэх зайлшгүй шаардлага гарч байна. БСШУС-ын сайдын 2018 оны А/459 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг

баталсан. Уг аргачлал нь сургалтын хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цогц үйл ажиллагааг төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай, тасралтгүй дэмжин ажиллах 10 жилийн тогтолцоог бий болгох зорилготой.

Тэгвэл сурах бичгийг зохиох, хэлэлцүүлэх, хянах, сайжруулах, хэвлэх, түгээх, танилцуулах эргэх холбоо бүхий үйл ажиллагааг дээрх цикл нэгдсэн тогтолцоонд нь зохион байгуулах хэрэгцээ гарч байгаа юм. Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг бодитойгоор буулгасан, түүний хэрэгжилтэд дэмжлэг болох “сайн” сурах бичиг, багшийн номыг боловсруулснаар багшлахуй болон суралцахуйн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой.

Одоогийн хүний нөөцийг 30 хувиар нэмэгдүүлбэл 2-3 сурах бичиг болон сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад давхар ажиллах ачааллыг бууруулах боломжтой юм. Ингэснээр дээрх хэмжээний сурах бичгийг шинэчлэх, сайжруулахад 1200-1300 орчим хүн, түвшин бүрийн сурах бичгийг шинэчлэхэд 3-4 жил, зарцуулах зардалд 6.5 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцооллоо.


Иймд сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлд сурах бичгийг сайжруулах үйл явцыг дараах байдлаар зохион байгуулахыг санал болгож байна.

Сурах бичгийг сайжруулах, шинэчлэхэд судалгаа чухал байна. Хэрэглэж буй сурах бичгийг судлах, юуг нь хэрхэн сайжруулах, шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг сурах бичигт хэрхэн тусгах зэргийг тодорхойлох, зохиогчийн багт танилцуулах, тэднийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлгийг сурах бичгийн эх зохиохоос өмнө зайлшгүй хийх шаардлагатай.

Сурах бичгийг шинэчлэн зохиохын өмнө дээрх судалгаа, шинжилгээ, сургалт, хэлэлцүүлгийг хийгээгүйн улмаас хэрэглэж буй сурах бичгийнхээ юуг нь сайжруулах нь бүрхэг, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын талаарх ойлголтоо нэгтгээгүй, зохиогчийн багийн гишүүдийн ойлголт зөрөөтэй гэх мэт асуудлууд гардаг.

Зураг 1

ХМЦ-ийн 10 жилийн цикл дэх сурах бичиг зохиох, хэвлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөлт



Тухайн түвшинд хэдэн хичээлийн ямар сурах бичгийг шинэчлэх шаардлагатайг тодорхойлж жагсаалт гаргах, зохиогчийн багийг бүрдүүлэх, шаардагдах санхүү зардлыг тооцоолох улмаар тэдгээрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын сайдын тушаалаар батлах зэргийг бэлтгэл ажлын хүрээнд хийхээр төлөвлөв. Мөн ЕБС-ийн багш нарын хичээл, сургалтаа зохион байгуулж буй бодит байдал болон хэрэгцээнд шинжилгээ хийх, тэдний саналыг сонсох, эх зохиоход баримтлах ерөнхий зарчмаа тодорхойлох (агуулга, бүтцийн онцлог, нүүрний тоо хэмжээ, ажлын дараалал) зэргийг багтаасан ажлын удирдамж боловсруулах хэрэгтэй.

Зохиогчийн нөөц, санхүүгийн боломж, цаг хугацааны төлөвлөлт зэргийг харгалзан үзэхэд бүх түвшний сурах бичгийн боловсруулалтыг нэгэн зэрэг эхлэх боломжгүй юм. Мөн сургалтын


хөтөлбөрийн боловсруулалтын хугацааг харгалзан дунд ангийн сурах бичгийн ажлыг бага ангийнхаас нэг жилийн дараа эхлэхээр төлөвлөсөн. Харин дунд, ахлах ангийн сурах бичгийн зохиогчдын давхцал их тул дунд ангийн сурах бичгийн эх зохиож эхэлснээс 2 жилийн дараа ахлах ангийн сурах бичгийн боловсруулалт эхлэх боломжтой гэж үзлээ.

Тухайн түвшний сурах бичгийг хэрэглэж эхлэхэд зохиогчийн санаа, тайлбар зэргийг сургалтаар дамжуулан багш нарт хүргэх, тэдэнд сурах бичгээ судлах боломж бүрдүүлэх зорилгоор нэг жилийн хугацаа төлөвлөсөн.

Нэг түвшний сурах бичгийн эх зохиохоос хэвлэх хүртэлх хугацааг 3 жил байхаар төлөвлөсөн бөгөөд эх зохиох, хэлэлцүүлэх, сайжруулах, эх бэлтгэх, хянах, хэвлэх бүхий л үйл ажиллагаанд зарцуулах хугацааг дараах зурагт үзүүлэв.

Зураг 2

Сурах бичгийг хэвлэн нийтлэх хугацаа, сараар



Улмаар дээрх гинжин хэлхээнд зарцуулах хугацаа болон оролцогч талуудын үүрэг, хариуцлагын тогтолцоог сурах бичгийн талаар баримтлах бодлого, зохицуулалтын журамд

тусгах шаардлагатай. Сурах бичгийн зохиогч ажлын хажуугаар ажилладаг тул чанартай гүйцэтгэлийг хангахын тулд эх зохиох хугацааг 12 сараас багагүй болгох хэрэгтэй. Үйл

ажиллагааны дараалал бүрд баримтлах хугацааг нарийвчилж төлөвлөх шаардлагатай байна. Мөн боловсруулсан хувилбарыг хэсэгчлэн ЕБС-ийн тухайн ангид заах, турших эсвэл багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг нь сонсох, зохиосон хувилбартаа тусгах, сайжруулах тогтолцоо бий болгох үүднээс уг үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тооцоолов. Сурах бичиг зохиоход ЕБС-ийн багшийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн болон орон нутгийн боловсрол хариуцсан байгууллагуудын оролцоог тодорхойлж, үйл ажиллагааны нэгдсэн зохион байгуулалтад орох хэрэгтэй юм. Бэлэн болсон сурах бичгийн эхийг хувилж, олшруулахын өмнө эцсийн хяналт хийх, батлах, хэвлэх боломжгүй тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй. Үйл ажиллагааны явц, үр дүн, тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүдийн талаар боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад төвлөрүүлж, талуудын зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэх, арга хэмжээ авч ажиллах боломжтой. Сурах бичгийн ашиглалтын хугацааг 4 жилээр тооцдог. Ашиглалт, түрээсийн тогтолцоо-эргэлтийн сангийн үйл ажиллагаанаас тодорхой санхүүгийн эх үүсвэр үүсгэж, сурах бичгийг сайжруулах (update)-д зарцуулдаг байх тогтолцоо бий болгох хэрэгтэй. Улмаар 4-6 жил тутамд сурах бичгийг сайжруулах ажлыг хийснээр түүний чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд бодит дэмжлэг үзүүлэх юм.

Дүгнэлт

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, улмаар бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд сурах бичгийн талаар хамаарах заалтуудын уялдаа холбоог харгалзан үзэх, сурах бичгийг судлах, судалгааны үндсэн дээр эх зохиох, сайжруулах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааны цаг хугацаа, оролцогч талууд, тэдний эрх үүрэг, хариуцлагын талаар тодорхойлох хэрэгцээ байна.

Өнгөрсөн жилүүдэд ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн дагуух сурах бичгийг шинэчлэх үйл явцад гаргасан баримт бичигт шинжилгээ хийснээр өмнөх туршлага, сургамжид тулгуурлан цаг хугацаа, хүний нөөц, санхүү зардлын боломжоо зөв тодорхойлох, хүрэх үр дүнг үнэлэх нарийвчилсан шалгуур боловсруулах, оролцогч этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхойлох, урьдчилсан стратеги төлөвлөлт хийх нь чухал байна.

Бидний судалгаагаар I-XII ангид судлах судлагдахуун бүрийн сурах бичиг (100 гаруй

тооны)-ийг шинэчлэх (эх зохиох, хянах, эх бэлтгэл)-д зарцуулсан хугацаа дунджаар 8-10 сар байна.

Нийт 221 нэрийн сурах бичиг, багшийн ном боловсруулахад давхардсан тоогоор 1000 орчим зохиогч, редактор оролцсон байна. Цаашид сурах бичиг зохиогч, судлаач эрдэмтдийн судалгааны ажлыг зохиогчийн эхийг боловсруулахдаа нас, сэтгэхүйн онцлог, хэрэгцээ, сонирхол гэх мэтийг үнэлэхэд чиглэсэн шалгуур, түүнийг үнэлж, дүгнэх арга, аргачлал бүхий практик судалгаанд суурилсан судалгааг боловсролын бүх түвшинд дэмжин ажиллах хэрэгцээ байна. I-XII ангид судлах судлагдахуун бүрийн сурах бичиг (100 гаруй тооны)-ийг шинэчлэх, сайжруулах хамгийн бодит хугацаа нь 6-7 жил байх нь зохистой болохыг бидний судалгаа баталж байна. Үүнээс бага хугацааны төлөвлөлт хийх боломжгүй юм. Сургалтын хөтөлбөрийн менежментийн 10 жилийн циклд үндэслэн бидний санал болгож буй төлөвлөлт нь хүний нөөц, зардал, хугацаа хамтад нь шийдэх оролдлого хийснээрээ шинэлэг, практикийн чухал ач холбогдолтой юм.

Ном зүй

Монгол улсын ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан, (2018). “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх” (Process) төсөл, Улаанбаатар хот, Би Си Ай ХХК

ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал. (2018). “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх” (Process) төсөл, Улаанбаатар хот, Би Си Ай ХХК

Боловсролын хүрээлэн. (2018). “Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан

Алтанцэцэг.Д, Лувсандорж.Ц, (2008) Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бодлого, төлөвлөлт, арга зам, Улаанбаатар, Экимто хэвлэлийн газар

Andy Smart, Shanti Jagannathan. (2018). Textbook policies in Asia (Development, publishing, printing, distribution, and future implications) Guidelines on Submission of Printed Textbooks for Review, Revised in January 2019, Retrieved from <https://www.edb.gov.hk>

Guiding Principles for Quality Textbooks, Revised in June 2016, Retrieved from <https://www.edb.gov.hk>

Planning for drafting and publishing of textbooks for General Education School

*Densmaa.J, Puntsagsuren.D, Khulan.N,
Institute of Education*

Abstract

Challenges for developing school textbooks and some recommendations for solution in the past 5-6 years, Mongolia has been using newly developed textbooks for 1-12 grade students, within the "core" curricula. However, there have been a number of challenges, such as delays in textbook delivery to customers, schools teaching without textbooks, using old textbooks for the newly adopted "core" curricula, or there are lack of textbooks for primary and secondary schools. We have conducted some research and assessed all ministerial orders and decisions issued during the above-mentioned period and how development, editing, printing, and distribution of textbooks have been implemented. The study shows that about 850 writers and editors have been involved in the development of 122 textbooks. Textbooks for primary, secondary, and high school were needed to be developed in phases, but our assessment have come to conclusion that the reason for the shortcoming was poor planning in human resource and required funding. We would like to make the following recommendations for solution: update the current documents for textbook policy and regulation; make a precise calculation for required human resource and funding for longer term, as well as the time required for each stage, starting from developing textbooks to delivering customers. Duties and liabilities for parties need to be detailed and action plan, which oversees the whole process should be formulated. We have presented you the outcome of our research and some recommendations to solve the issues.

Keywords

Textbook, writer, human resource, time, planning, costs
